Монгол улсад үндэсний сувилагч мэргэжилтэн бэлтгэсэн түүхэн үндсийг судлах нь

Б.Буяндэлгэр[1], Д.Баттогтох[1]

[1]АШУҮИС. СС
Цахим хаяг: buyandelger.b@mnums.edu.mn, Утас: 99131584

Түлхүүр үг:

Сувилахуйн түүх
Сувилахуйн боловсрол,
Сувилахуйн хүний нөөц
Сувилахуйн сургууль

Товч утга: Монгол улсад сувилагч мэргэжилтэн бэлтгэх болсон нь тухайн үеийн нийгэм-улс төр, түүхийн зайлшгүй шаардлагаас үүдэлтэй бөгөөд уг үйл явцын үндсэн шалтгаан, тэдгээрт нөлөөлсөн хүчин зүйлүүдийг тодруулах нь ач холбогдолтой. Тиймээс бид Монгол улсын сувилахуйн салбарын үндэсний боловсон хүчин бэлтгэх тогтолцоо бүрэлдэж эхлэсэн үеийн түүхийг судлах зорилго дэвшүүлсэн юм. Энэ хүрээнд нэгдүгээрт: Монгол оронд орчин цагийн сувилахуйн нөлөө хэрхэн тусаж байсныг тоймлох, хоёрдугаарт: XX зууны эхэн үеийн эмнэлгүүдийн сувилахуйн боловсон хүчин бэлтгэхэд үзүүлсэн нөлөөг тодруулах, гуравдугаарт: сувилахуйн чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэж эхлэсэн түүхийг судлах зорилтуудыг тавьсан. Судалгааны үр дүнгээс үзэхэд, Монголын уламжлалт нийгэмд сувилахуйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж ирсэн тогтолцоо байгаагүй нь тухайн үед байсан оточ нар нь хүртээмжгүй байснаас гадна албан ёсны боловсролын тогтолцоо бүрэлдээгүй байсантай холбоотой. XX зууны эхэн үед Монгол оронд нээгдсэн эмнэлгүүд нь орчин цагийн сувилахуйн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог бүрэлдүүлэн бий болгоход ихээхэн нөлөө үзүүлсэн. 1929 онд орчин цагийн сувилахуйн ухаанаар мэргэшсэн үндэсний боловсон хүчнийг сургалтын байгууллагад түшиглэн бэлтгэж эхэлсэн нь өнөөгийн манай улсын сувилахуйн боловсрол олгох тогтолцооны эхлэл байлаа.

Үндэслэл: Манай оронд сувилахуйн салбарын үндэсний боловсон хүчин бэлтгэж эхлээд 90 гаруй жилийн нүүрийг үзэж байгаа ч бакалаврын болон дипломын боловсрол олгох түвшний сургалтанд[4] заавал судлахаар тусгасан “Монголын түүх, соёл, ёс заншил” хичээлд сувилахуйн түүхийн агуулга харьцангуй дутмаг байгаа нь сувилахуйн салбарын түүхийн судалгаа төдий л өргөжиж амжаагүйг илтгэж байна. Тийм учраас өөрийн орны сувилахуйн боловсролын тогтолцоо бүрэлдсэн түүхийг сөхөн судлах нь онолын төдийгүй практик ач холбогдолтой.

Зорилго: Тус өгүүлэлд Монгол улсын сувилахуйн салбарын үндэсний боловсон хүчин бэлтгэх тогтолцоо бүрэлдэж эхлэсэн үеийн түүхийг судлах зорилго дэвшүүлсэн юм. Энэ хүрээнд нэгдүгээрт: Монгол оронд орчин цагийн сувилахуйн нөлөө хэрхэн тусаж байсныг тоймлох, хоёрдугаарт: XX зууны эхэн үеийн манай улсын эрүүл мэндийн тогтолцооны байдлыг тодруулах, гуравдугаарт: сувилахуйн чиглэлээр үндэсний боловсон хүчин бэлтгэж эхлэсэн түүхийг судлах зорилтуудыг тавьсан.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй: Судалгаанд Монголын түүхийн эх сурвалж болон түүхийн суурь судалгааны бүтээлүүд, архивын зарим баримтыг хэрэглэгдэхүүн болгож баримт бичигт дүн шинжилгээ хийх, түүхэн ба логик аргуудыг ашигласан.

Үр дүн: Монголын уламжлалт нийгмийн соёл, ёс заншил, амьдрах арга ухааны онцлогтой уялдсан сувилах болон эмчлэх аргууд 2500 гаруй жилийн түүхтэй[15] боловч асран сувилах үйл ажиллагааг тусгайлан эрхлэх мэргэжилтэн болон сурган бэлтгэх талаар түүхийн сурвалж бичгүүдэд тодорхой өгүүлсэн зүйл байхгүй. Энэ нь Монголын уламжлалт нийгэмд сувилахуйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж ирсэн тогтолцоо байгаагүйг илтгэж байна. Гэвч сувилахуйн тусламжийг хэрэгцээт үед нь өдөр тутмын амьдралын хэв маягтай уялдуулан үзүүлсээр байсан нь дамжиггүй.

Монголд XYI зууны дунд үеэс шарын шашин дэлгэрсэнтэй[18] уялдан шашны зарим сүм хийдэд монгол эмнэлгийн сургуулиуд байгуулагдан оточ нарыг бэлтгэж, эмчлэн сувилах ур чадварыг эзэмшүүлэхээс[15] гадна ном бүтээлдээ сувилах арга ухааны талаар танилцуулж[6] байсан боловч сувилагч мэргэжилтнийг бие даан бэлтгэж байсангүй. Үүний учир шалтгаан нь тухайн үед байсан оточ нар нь хүртээмжгүй байснаас[2, 9] гадна хүн амын дундах албан ёсны боловсролын тогтолцоо бүрэлдэн тогтоогүй байсантай холбоотой байв.

XIX зууны эхэн үеэс эхлээд Монгол орноор дамжин өнгөрсөн (Орос эмч Реймен 1811 он г.м) гадаадын эмч нар Монголчуудын уламжлалт арга барилаараа төдийлөн эмчлэн сувилж чадахгүй байсан зарим төрлийн өвчнийг амжилттай эмчлэн сувилж байсан учраас Монгол хүмүүсийг орчин цагийн эмчилгээ сувилахуйн чиглэлээр сургах хүсэлт[14] ч нийгмийн элит хэсгийн дунд байжээ. Гэвч тэрхүү хүсэл зорилго нь түүхэн тухайн үеийн нийгэм-улс төрийн болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан бодит биеллээ олж чадаагүй юм.

Түүхэн хөгжлийн явцад XX зууны эхэн үе хүрэхэд Монгол оронд орчин үеийн анагаах ухаанд суурилсан эмнэлгүүд[14] цөөн боловч (1901 онд нээгдсэн цэргийн эмнэлэг, 1906 онд нээгдсэн Оросын консулын эмчилгээний газар, 1909 онд нээгдсэн Оросын консулын газрын дэргэдэх эмнэлэг, 1913 оноос ажилласан Оросын улаан загалмайн нийгэмлэгийн Хужирбулан дахь эмнэлэг г.м) үйл ажиллагаагаа явуулж ард олонд тусламж үйлчилгээ үзүүлж ирсэн нь орчин цагийн сувилахуйн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог бүрэлдүүлэн бий болгоход ихээхэн нөлөө үзүүлсэн. Тус үйл явцыг түргэтгэхэд XX зууны эхэн үед Монголд болсон удаа дараагийн хувьсгал, тэдгээрийг дагалдан гарсан нийгэм-улс төрийн бодлого шийдвэрүүд чухал түлхэц болсон. Тухайлбал, 1921 оноос хойш орчин цагийн сувилахуйн тусламж үйлчилгээг улс орныг батлан хамгаалах үйл хэрэгтэй уялдуулан зохион байгуулах болсон байдаг. Үүний гэрч нь 1921 онд Алтанбулаг хотод цэргийн яамны хүн эмнэлгийн хэлтэс,[7] улмаар Их хүрээнд "Өвчтэй хүнийг эмчлэх хороо" байгуулсан[1] бол 1924 онд "Хувьсгалт улаан цэргийн лазарет" бие даан байгуулагдаж, хажуудаа зургаан сарын хугацаатай сувилагчийн курсыг ажиллуулж эхлэсэн байна.

Улмаар 1925 онд Дотоод яамны дэргэд Эрүүлийг хамгаалах газар байгуулж, мөн ондоо 15 ортой иргэний эмнэлэг байгуулсанаар[12] эмч нараас гадна 4 сувилагчийн орон тоотой ажиллаж[8] байжээ. Ийнхүү манай оронд эмнэлгийн байгууллагууд өсөн нэмэгдэж, нийгэмд эрүүл мэндийн салбар бие даасан тогтолцоо болон хөгжих нь илэрхий болсноор түүнд ажиллах сувилагч мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах зүй ёсны шаардлага тулгарч байлаа. Улмаар 1926 онд төв эмнэлгийг өргөтгөхөөс гадна Ховд, Улиастай, Цэцэрлэг, Алтанбулаг, Өндөрхаанд эмнэлгүүд байгуулж түүнд ажиллах сувилагч мэргэжилтнүүдийг орхигдуулалгүйгээр бэлтгэх ажил нэн шаардлагатай болсон байна. Ийнхүү сувилагч нарыг бэлтгэхийн тулд 6 сарын курс хичээллүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд сувилагч нарын курст 30 хүртэлх насны бичиг үсэг сайн төсөөлдөг эмэгтэйчүүдийг[13] суралцуулахаар тогтжээ.

БНМАУ-ын II их хуралд ерөнхий сайд Б.Цэрэндорж засгийн газрын тайлан илтгэлдээ[10] арван дөрөв, арван тав, арван зургадугаар зүйлүүдэд тухайлан танилцуулсаны үндсэн дээр тус их хурлаас "гадаадын ба дотоодын анагаах ухааны сургууль курсээр үндэсний боловсон хүчнүүдийг бэлтгэх"[3] асуудлыг тусган тогтоол гаргасныг Ардын эрүүлийг хамгаалах газраас амжилттай хэрэгжүүлж 1926 оны 9 сараас Төв эмнэлгийн дэргэд сувилагчийн курс байгуулагдсан юм. Гэвч курсууд нь богино хугацааны сургалт байсан учраас түүнийг улам бүр чанаржуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах зорилгоор Намын VII их хурлын (1928) шийдвэрийг[9] үндэслэн Эрүүлийг Хамгаалах Яамны шийдвэрээр 1929 оны 2 дугаар сарын 15-нд Улаанбаатар хотод сувилагчийн сургуулийг 20 сурагчтай 27500 төгрөгний төсөвтэйгөөр байгуулж, сургалтын хугацааг 2 жилээр тогтоожээ[17]. Ийнхүү Монгол оронд орчин цагийн сувилахуйн ухаанаар мэргэшсэн үндэсний боловсон хүчнийг бие даасан сургалтын байгууллагад түшиглэн бэлтгэж эхэлсэн нь өнөөгийн манай улсын сувилахуйн боловсрол олгох тогтолцооны эхлэл байлаа.

Сувилагчийн мэргэжлээр суралцагчид нь тухайн үеийн нийгэмд ихээхэн эрэлт хэрэгцээ бүхий чухал боловсон хүчин байсан учраас хоол, байраар үнэгүй хангахын дээр сар бүр таван төгрөгийн тэтгэлэг олгож байсан ажээ. Ийнхүү Монгол оронд албан ёсоор сургалтын байгууллагад түшиглэн сувилагч мэргэжилтнийг бэлтгэхэд 20 хүн анх элссэнээс 1931 онд 17 хүн сувилагч мэргэжил эзэмшин анхны үнэмлэх гардан авсан байдаг.

Эрүүлийг хамгаалахын салбарын хөгжил нь боловсон хүчний хэрэгцээ шаардлагыг гадаадад явуулж бэлтгэхийн зэрэгцээ сувилагч болон эмнэлгийн бусад мэргэжилтэн бэлтгэх үндэсний тогтолцоог үүсгэн байгуулахад зайлшгүй хүргэсэн нь "үндэсний бие даасан байдлыг хамгаалах, хадгалахын төлөө явуулж байсан"[11] тухайн үеийн төр, засгийн бодлоготой ч нийцэж байлаа.

Дүгнэлт:

1. Монголчууд XIX зууны эхэн үеэс манай улсаар дамжин өнгөрсөн болон суурьшин амьдарсан Европ иргэдийн оролцоотойгоор түгээмэл биш боловч орчин цагийн сувилахуйн тусламжийг зохих хэмжээгээр хүртэж байжээ.
2. Манай орны эрүүлийг хамгаалахын салбарын хөгжилтэй уялдан сувилагч мэргэжилтэн бэлтгэх үндэсний тогтолцоо бүрэлдэн тогтжээ.
3. 1924 оноос эмнэлгүүдийг түшиглэн ажилуулж эхлэсэн сувилагчийн курсууд нь манай орны орчин цагийн сувилахуйн боловсролын эхлэл байсан бөгөөд 1929 оноос тогтмол үйл ажиллагаатай болон бие даасан сургуулийн бүтцээр ажиллах болсон байна.

Ном зүй:

1. *Батлан хамгаалахын төв архив. Ф.1. ХН.12. Х.43*
2. *Батсүх Д нар. (2001). Аврахуйн ачтанууд буюу гэгээн үйлстэний бичээс. УБ.*
3. *БНМАУ-ын II их хурал, БНМАУ-ын I, II, III бага хурал. (2009). УБ.*
4. *БСШУЯ-ны сайдын А/285 тоот тушаал. (2014).*
5. *Буяндэлгэр Б нар. (2019). Сувилахуйн сургууль 90 жил. УБ.*
6. *Жигмэд Б. (1990). Монгол анагаах ухаан, үндсэн онол, товч түүх. "Монголын анагаах ухаан" 1 (73)*
7. *Зэвсэгт хүчний ар тал. (2007). УБ.*
8. *Ичинноров С. (2013). Түүхийн үнэний мөрөөр V. "Европын боловсон эмнэлэг Монгол оронд нэвтэрч хөгжсөн түүхээс". УБ.*
9. *МАХН-ын их, бага хурал, төв хорооны бүгд хурлуудын шийдвэр (1921-1939). (1957). Боть I. УБ.*
10. *Монгол Улсын гадаад бодлого: Хичээнгүй сайд Балингийн Цэрэндорж. (2011). УБ.*
11. *Монгол Улсын түүх. (2003). V боть. УБ.*
12. *85 жил, 85 түүхт явдал. (2014). УБ.*
13. *Үндэсний төв архивын сан хөмрөг. Улс төрийн товчооны фонд. 1-49-56-т.*
14. *Цэргийн эмч нарын Монголын эрүүл мэндийн салбарт оруулсан хувь нэмэр. (2011). УБ.*
15. *Цэрэндагва Д, Оюунгоо Б. (2019). Монголын уламжлалт анагаахын эрдэм ухааны 3 цагийн хэлхээс. Монгол анагаах ухааны дэг, сургуулийн үүсэл, хөгжилт, хөгжлийн шинэ концепци. УБ.*
16. *Энхбаатар Л. (2015). Монголын уугам эмнэлгийн түүх оршвой. 1925-1940. УБ.*
17. *Батсүх Т, Володя Я, Дагданбазар Б. (2009). Энэрэхүйн эрдэм дэлгэрүүлснийг багцалсан шашдир. УБ.*
18. *https://mongoltoli.mn/history/h/843. Монголын түүхийн тайлбар толь.*

Studying the History of the Training of National Nursing Personnel in Mongolia

Buyandelger B[1], Battogtokh D[1]

[1]Nursing School. MNUMS
Email: buyandelger.b@mnums.edu.mn, Tel: 99131584

Background and Purpose: The history of the formation of the national nursing education system in Mongolia has been studied. In this context: 1. Review the impact of modern nursing on Mongolia; 2. To clarify the state of the health system in our country in the early twentieth century; 3. The goal is to study the history of the training of national nursing personnel.

Research Materials and Methods: The study used historical and logical methods to analyze Mongolian historical sources and basic historical research works, as well as some archival documents.

Results: The victory of the Mongolian People's Revolution in 1921 did not mean that Mongolians became acquainted with modern nursing and health care. Since the beginning of the 19th century, we have been acquainted with Europeans who have passed through our country and settled there. The development of the health sector has created a need for human resources. To ensure this, it is necessary training abroad, on the one hand, and to establish a national system for training nurses and medical professionals, on the other. Nursing courses, which have been operating in hospitals since 1924, were the beginning of modern health education in our country. Subsequently, in 1929, it became a permanent and independent school.

Key word: Mongolia, Nursing Personnel, History